

**“СУРАЛЦАХАД ЭЭЛТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ СУРГУУЛЬ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЖИШИГ ЗАГВАР БОЛОВСРУУЛАХ
ЗӨВЛӨХИЙН АЖЛЫН ДААЛГАВАР**

1. Үндэслэл

Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах, сайн сайхан байдлыг хангах нь үндэсний хэмжээнд тэргүүлэх зорилгуудын нэг юм.

2024 оны 01 сарын 17-ны өдөр соёрхон баталж, 09 сарын 01-ны өдрөөс мөрдөж эхэлсэн Хүүхэд хамгааллын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн зорилго нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бий болгох, хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад оршино гэж заасан.

Хүүхдийг Ивээх Сан Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах үйлсэд сүүлийн 32 жилийн турш тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн. Тус байгууллага нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог хөгжүүлэх, нийгмийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эцэг эхийн хараа хяналтгүй хүүхдүүдийг дэмжих, олон нийтэд түшиглэсэн хүүхэд хамгааллын үйлчилгээг бий болгох зэргээр төрийн байгууллага, иргэний нийгэм, олон нийттэй хамтран ажилласан арвин туршлагатай.

ХИС-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.savethechildren.mn цахим хуудаснаас авна уу.

2. Зөвлөхийн ажлын зорилго

Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн сангийн бүтэц, агуулга, арга зүй, асуумжийг Хүүхэд хамгааллын тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль болон бусад холбогдох хууль, олон улсын жишигт нийцүүлэн боловсруулан, турших

3. Ажлын цар хүрээ, үүрэг даалгавар

- Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн сангийн ерөнхий зураглалыг холбогдох цахим систем, мэдээллийн баазуудтай уялдуулан гаргах
- Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, асуумжуудыг шинэчлэгдсэн хууль, журамд нийцүүлэн дахин шинэчлэх
- Хүүхэд хамгааллын үйлчилгээг мэдээллийн санд бүртгэх, хөтлөх, хадгалах, нэгтгэх бүтцийг гаргаж, хэрэглэгчийн гарын авлага бэлтгэх
- Бэлэн болсон мэдээллийн сангийн агуулгыг төсөлд хамрагдаж байгаа ерөнхий боловсролын сургууль дээр цаасан хэлбэрээр турших, үр дүнг дүгнэж, сайжруулалт хийх
- Холбогдох талуудад танилцуулах, санал авах, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулан эцэслэх

3. Хүлээгдэж буй үр дүн

Гүйцэтгэгч нь захиалагч талд дараах бүтээгдэхүүнийг хүлээлгэж өгнө. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын мэдээллийн сангийн бүтэц, агуулгын зураглал
- Эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн асуумж, оноожуулах аргачлал
- Мэдээллийн санд оруулах хүүхэд хамгааллын үйлчилгээний маягт, холбогдох баримт бичгүүд, түүнийг ашиглах хэрэглэгчийн гарын авлага
- Зөвлөх үйлчилгээний тайлан /англи-монгол/

4. Хамрах хүрээ

- Төслийн зорилтот 18 ерөнхий боловсролын сургууль

5. Хугацаа

Гүйцэтгэгч нь 2026 оны 10-р сарын 01-нээс 2026 оны 11-р сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд гэрээт ажлыг гүйцэтгэнэ.

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Тайлбар
1	Судалгаа хийх, зураглал гаргах	Ажлын 5 хоног	Монгол улсад ашиглагдаж буй хүүхдийн хамгааллын болон боловсролын салбарын ижил төстэй мэдээллийн сангийн бүтэц, үйл ажиллагааг судалж, давхардал үүсгэлгүй, холбогдож ажиллах боломжит хувилбарыг тодорхойлно. Мөн ерөнхий боловсролын сургуулийн олон улсад ашиглагдаж байгаа мэдээллийн сангуудын хэлбэрийг судалж, Монгол улсад тохирох загварыг тодорхойлно.
2	Эрсдэлийн үнэлгээний асуумж, арга зүйг шинэчлэх	Ажлын 5 хоног	Одоо ашиглагдаж байгаа асуумж, МУ-ын хүүхэд хамгааллын мэдээллийн санд ашиглах арга зүй, олон улсын жишгийг харьцуулан судалж, шинэчлэгдсэн ХХтХ болон Боловсролын багц хуулиудад нийцсэн асуумж, арга зүйг тодорхойлно.
3	Хүүхэд хамгааллын үйлчилгээг эхлэхээс дуусах хүртэлх үе шатуудыг батлагдсан асуумж, маягтуудын дагуу мэдээллийн санд бүртгэх урсгалыг зураглах	Ажлын 5 хоног	Хүүхэд хамгааллын үйлчилгээг эхлэхээс дуусах хүртэл үе шатуудыг батлагдсан асуумж, маягтуудын дагуу мэдээллийн санд бүртгэх урсгал зураглагдана.
4	Мэдээллийн сангийн бүртгэлийг турших, сайжруулалт хийх	Ажлын 10 хоног	Төсөл хэрэгжиж байгаа ерөнхий боловсролын сургууль дээр мэдээллийн сангийн ашиглалтыг туршиж, сайжруулалт хийнэ.

5	Хэрэглэгчийн гарын авлага боловсруулах, эцэслэх	Ажлын 7 хоног	Мэдээллийн санг ашиглах хэрэглэгчдэд зориулсан гарын авлага боловсруулна. Мөн тэдгээр хэрэглэгчдийн мэдээллийн санд нэвтрэх эрхийн хязгаарыг тодорхойлно.
6	Зөвлөх үйлчилгээний үр дүнгийн тайлан бичих, захиалагчид хүлээлгэн өгөх	Ажлын 3 хоног	Захиалагч тал гэрээнд тусгагдсан ажлын гүйцэтгэлийг үнэлж төлбөр тооцоог дуусгана.

6. Гүйцэтгэгчид тавигдах шаардлага

- Хүүхдийн эрх, хамгаалал, нийгмийн хамгааллын чиглэлээр мэргэшсэн, энэ чиглэлийн үнэлгээ, судалгаа хийж гүйцэтгэсэн, ном, гарын авлага боловсруулсан туршлагатай байх;
- Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, нийгмийн ажлын чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- Байгууллага болон төсөлд сургамжтай мэдээллийг судалгаанд үндэслэн боловсруулж байсан туршлагатай байх;
- Монгол, Англи хэл дээр бичиг баримтыг мэргэжлийн түвшинд боловсруулах чадвартай байх;

7. Бүрдүүлэх материал

Сонирхсон зөвлөх доорх бичиг баримтыг 2026 оны 09-р сарын 25-ний өдөр багтаан ирүүлнэ үү.

1. Гэрээт ажлыг гүйцэтгэх сонирхлоо илэрхийлсэн захидал.
 - Гүйцэтгэх ажлын талаар ойлголттой байгаагаа харуулсан байх;
 - Ажил гүйцэтгэх арга зүйгээ тайлбарлаж, төлөвлөгөөг нарийвчлан тусгасан байх;
2. Өөрийн туршлага, мэргэжлийг тусгасан танилцуулгыг (CV) Монгол эсвэл Англи хэл дээр ирүүлэх;
3. Өмнө гүйцэтгэж байсан ижил төстэй ажлын материалууд (жишээ нь, өмнө боловсруулж байсан ном гарын авлага, үнэлгээ, судалгааны тайлан, зөвлөмж). Монгол эсвэл Англи хэл дээр ирүүлэх.
4. Зөвлөх үйлчилгээний хөлс, бусад зардлыг багтаасан үнийн санал. Монгол эсвэл Англи хэл дээр ирүүлэх

Өргөдлөө дараах хаягаар илгээнэ үү:

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төв, 4-р давхар, Хүүхдийг Ивээх Сан. (Нийслэлийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн урд талд) Ирүүлэх бичиг баримтуудыг PDF файл болгон mongolia.procurement@savethechildren.org е-мэйл хаягаар 2026 оны 09-р сарын 25-ны өдөр, 15:00 цагаас өмнө ирүүлнэ. Шаардлага хангасан өргөдөл гаргагчтай эргэн холбогдоно.

Лавлах утас: +976-11-329365, +976-11-329371

8. Тайлагналт, хяналт

Гүйцэтгэгч нь гэрээт ажлын турш ХИС-гийн зүгээс хүүхэд хамгааллын төслийн нэгж мэргэжлийн туслалцаа дэмжлэгийг үзүүлнэ. Зөвлөх нь ажлын гүйцэтгэлийн тайлан, мэдээллийг ХИС-гийн төслийн зохицуулагчид тогтмол тайлагнана.